

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: [khuanganm@audit.gov.mn](mailto:khuanganm@audit.gov.mn)  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)  
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: [asaudit.mn@gmail.com](mailto:asaudit.mn@gmail.com)  
Аудитор: А.Батжаргал  
Утас: 99291595 Цахим хаяг: [asaudit.zul@gmail.com](mailto:asaudit.zul@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	14
5.1 Төлбөрийн акт .....	14
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Е.АЙНУР ТАНАА

2023.02.17 № 94  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлүүн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

### Аудитын гол асуудал

Мөнгөн гүйлгээний зардлын ангилалыг зөв тусгах асуудлыг сайжруулах шаардлагатай байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,708,328.64	81,080,861.81
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	50,610,214.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	50,610,214.37
3121	Төгрөг	-	50,610,214.37
31211	Төрийн сангийн харилцах	-	50,610,214.37
35	БАРАА МАТЕРИАЛ	28,150,151.64	30,470,647.44
354	Хангамжийн материал	28,150,151.64	30,470,647.44
35410	Бичиг хэргийн материал	247,650.00	403,000.00
35420	Аж ахуйн материал	4,507,095.00	7,039,723.00
35440	Түлш шатах тослох материал	8,137,209.99	6,579,181.99
35460	Хүнсний материал	5,403,908.65	5,419,454.45
35470	Бусад хангамжийн материал	9,854,288.00	11,029,288.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	346,719,532.32	341,421,126.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	346,719,532.32	341,421,126.28
392	Биет хөрөнгө	306,323,532.32	301,135,126.28
39201	Барилга, байгууламж	286,206,428.00	286,206,428.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,007,641.56)	(42,225,109.16)
39205	Машин, тоног төхөөрөмж	17,605,281.00	27,422,281.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,269,785.99)	(15,189,254.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,431,692.00	33,431,692.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,570,127.76)	(16,148,752.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,974,146.81	17,974,146.81
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,771,989.18)	(4,061,834.34)
39217	Номын фонд	13,725,529.00	13,725,529.00
393	Биет бус хөрөнгө	40,396,000.00	40,286,000.00
39301	Програм хангамж	660,000.00	660,000.00
39302	Хасагдуулга	(264,000.00)	(374,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	375,427,860.96	422,501,988.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	375,427,860.96	422,501,988.09
51	Засгийн газрын хувь оролцоо	375,427,860.96	422,501,988.09
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	92,947,458.00	92,947,458.00
51101	Өмч: -Төрийн өмч	92,947,458.00	92,947,458.00
512	Хуримтлагдсан үр дүн	201,256,503.34	248,330,630.47
51210	Өмнөх үеийн үр дүн	201,256,503.34	201,256,503.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	47,074,127.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	81,223,899.62	81,223,899.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	375,427,860.96	422,501,988.09

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	275,935,905.81	406,963,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,978,544.00	9,050,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,978,544.00	9,050,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,978,544.00	9,050,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,978,544.00	9,050,000.00

Дэлүүн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,254,361.81	43,141,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	232,703,000.00	354,772,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,315,000.00	43,141,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,315,000.00	43,141,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	272,817,846.65	359,889,372.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	272,817,846.65	359,889,372.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,136,291.65	342,170,356.87
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	188,457,994.00	242,309,236.63
210101	Цалин	188,457,994.00	191,039,285.63
210102	Нэмэгдэл цалин	-	42,912,220.00
210104	Урамшуулал	-	8,357,731.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,518,700.00	33,755,400.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,518,700.00	22,953,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	2,700,400.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	2,160,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	540,100.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	5,400,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,727,380.00	18,190,028.00
210301	Гэрэл цахилгааны зардал	789,580.00	1,388,000.00
210302	Түлш, халаалтын зардал	10,937,800.00	16,802,028.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,297,281.00	3,000,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,447,031.00	3,000,000.00
2105	Нормативт зардал	12,629,601.10	13,046,936.20
210502	Хоол	11,425,951.10	13,046,936.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	450,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	442,500.00	540,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,460,935.55	30,878,756.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,866,000.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,818,250.00	1,897,350.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,642,685.55	20,115,406.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,681,555.00	17,719,016.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,662,550.00	17,718,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,662,550.00	9,813,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	7,905,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,019,005.00	216.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,019,005.00	216.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	3,118,059.16	47,074,127.13
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	3,118,059.16	47,074,127.13

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

ДАНС	Үзүүлэлт	Үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	248,486,680.00	397,913,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	248,486,680.00	397,913,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	232,703,000.00	354,772,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,315,000.00	43,141,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,315,000.00	43,141,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	245,180,180.00	337,486,285.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,180,180.00	337,486,285.63
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,028,775.00	319,858,969.63
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	183,619,800.00	241,751,059.63
210101	Үндсэн цалин	169,939,800.00	190,773,974.63
210102	Нэмэгдэл	-	42,619,354.00
210104	Үр дүнгийн урамшуулал	9,142,200.00	8,357,731.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	24,518,700.00	33,755,400.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,253,900.00	22,953,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,816,200.00	2,700,400.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,453,000.00	2,160,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	363,200.00	540,100.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,632,400.00	5,400,800.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	10,815,000.00	18,132,000.00
210301	Гэрэл цахилгааны зардал		

Дэлүүн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		888,000.00	1,388,000.00
210302	Түлш, халаалтын зардал	8,927,000.00	15,244,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,000,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	10,025,675.00	13,181,210.00
210502	Хоол, хүнс	9,316,175.00	13,181,210.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	439,900.00	540,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,735,800.00	11,999,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,604,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	3,735,800.00	2,394,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,151,405.00	17,627,316.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,132,400.00	17,627,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	6,132,400.00	9,721,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	7,905,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,019,005.00	216.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,019,005.00	216.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,306,500.00	60,427,214.37
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,306,500.00	9,817,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,306,500.00	9,817,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,306,500.00	9,817,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,306,500.00	9,817,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,306,500.00)	(9,817,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	50,610,214.37
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	50,610,214.37

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511	51300	51210+51220	

<b>C08</b>	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	92,947,458.00	81,223,899.62	201,256,503.34	375,427,860.96
<b>D01</b>	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	92,947,458.00	81,223,899.62	201,256,503.34	375,427,860.96
<b>D02</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>D03</b>	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	92,947,458.00	81,223,899.62	201,256,503.34	375,427,860.96
<b>D08</b>	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	47,074,127.13	47,074,127.13
<b>D09</b>	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	<b>92,947,458.00</b>	<b>81,223,899.62</b>	<b>248,330,630.47</b>	<b>422,501,988.09</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>397,913,500.00</b>	<b>347,303,069.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	397,913,500.00	347,303,069.63
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	380,286,400.00	329,675,969.63
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	273,959,900.00	241,751,059.63
<b>210101</b>	Үндсэн цалин	215,735,600.00	190,773,974.63
<b>210102</b>	Нэмэгдэл	48,749,600.00	42,619,354.00
<b>210104</b>	Урамшуулал	9,474,700.00	8,357,731.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,755,400.00	33,755,400.00
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	22,953,800.00	22,953,800.00
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	2,700,400.00	2,700,400.00
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	2,160,300.00	2,160,300.00
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	540,100.00	540,100.00
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	5,400,800.00	5,400,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,132,000.00	18,132,000.00
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	1,388,000.00	1,388,000.00
<b>210302</b>	Түлш, халаалт	15,244,000.00	15,244,000.00
<b>210303</b>	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,773,800.00	13,181,210.00
<b>210502</b>	Хоол, хүнс	29,773,800.00	13,181,210.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00
<b>210604</b>	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,511,800.00	1,137,000.00
<b>210806</b>	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,511,800.00	1,137,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,653,500.00	21,219,300.00
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	20,258,800.00	18,824,600.00
<b>210902</b>	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,700.00	2,394,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	17,627,100.00	17,627,100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,627,100.00	17,627,100.00

Дэлүүн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,721,800.00	9,721,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,905,300.00	7,905,300.00
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>397,913,500.00</b>	<b>397,913,284.00</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,772,300.00	354,772,300.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	43,141,200.00	43,140,984.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		50,610,214.37
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	12.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв аваагүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2022 онд “Суралцагчийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бие даан сурах үйлийг дэмжихэд бүх талын оролцоог ханган, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж үр дүнтэй хэрэгжүүлэх
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг ахиулах
- Даалгаварт суурилсан арга зүйг боловсруулж, сургалтын чанарт ахиц гаргах.
- Багш, ажилчид, сурагчдыг стрессээс сэргийлэх, айдас түгшүүр, сэтгэл зовнилгүй ажиллах, суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжүүлэх, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжин оролцоог хангаж, сургууль завсардахаас сэргийлэн, эцэг эх олон нийттэй хамтран ажиллах.
- Монгол хэл бичгийн чадварыг сайжруулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх.
- "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3"-ын хүрээнд сургуулийн мэргэжлийн бүлгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.
- Сурагчдыг тэгш хамааруулан сургах үйлийг дэмжих дэмжлэгийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

БӨА-2023/62/НА-СТА-ТШЗ

### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн захирлын 2022 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн А-03 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дэлүүн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47.0 сая төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	50.610.2	50.610.2
Авлага	558.1	0	0
Бараа материал	28.150.1	30.470.6	2.320.5
Үндсэн хөрөнгө	346.719.5	341.421.1	-5.298.4
<u>Нийт хөрөнгө</u>	<b>375.427.8</b>	<b>422.501.9</b>	<b>47.074.1</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	375.427.8	422.501.9	47.074.1
<u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u>	<b>375.427.8</b>	<b>422.501.9</b>	<b>47.074.1</b>

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 50.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь батлагдсан төсвөөс цалингийн зардал, хоол хүнс, бараа үйлчилгээний бусад зардлуудын хэмнэлт байна. Цалингийн хэмнэлт 32.1 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 63.4% хувийг, хоолны зардлын хэмнэлт 16.5 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 32.6 хувийг, бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлт 1.4 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 2.7 хувийг тус тус эзэлж байна.

Авлагын дансны оны эхний 0.5 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 5.2 сая төгрөгөөр буурсан нь 14.8 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, үндсэн хөрөнгөнд тайлант онд 20.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 370.4 сая, орон нутгийн төсвөөс 43.1 сая, нийт зарлагыг 413.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

БӨА-2023/62/НА-СТА-ТШЗ

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 15.7 сая төгрөгөөр бууруулж 397.8 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 354.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 43.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 354.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 43.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 347.2 сая төгрөг буюу 85.7 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлын төсвийг 24.9 сая төгрөгөөр, нэмэгдэл цалингийн төсвийг 6.1 сая төгрөгөөр, урамшуулалт цалингаас 1.1 сая төгрөгөөр, хоол хүнснээс 16.5 төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	1,511,800.00	1,137,000.00	374,800.00	75%
2	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	21,969,300.00	20,535,100.00	1,434,200.00	91%
3	Эрүүл мэндийн арга хэмжээ	684,200.00	684,200.00	0.00	100%
4	Боловсролын арга хэмжээ	251,738,800.00	219,530,175.00	32,208,625.00	
5	Үдийн цай хөтөлбөр	9,721,800.00	9,721,800.00	0.00	100%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	7,905,300.00	7,905,300.00	0.00	100%
7	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	29,773,800.00	13,181,210.00	16,592,590.00	44%
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	31,467,300.00	31,467,300.00	0.00	100%
	<b>Дүн</b>	<b>354,772,300.00</b>	<b>304,162,085.00</b>	<b>50,610,215.00</b>	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор А.Батжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 272.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг БӨА-2023/62/НА-СТА-ТШЗ

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дэлүүн сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуульд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 5.4 сая төгрөгийн 1 зөвлөмж, 162.5 сая төгрөгийн 2 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	162,484.9	3	162,484.9	100%
Зөвлөмж	1	5,400.0	1	5,400.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>167,84.9</b>	<b>4</b>	<b>167,884.9</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 9.8 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Мөнгөн гүйлгээний тайланд биет хөрөнгө худалдан авсан 9.8 сая төгрөгийн гүйлгээг үйл ажиллагааны зардалд оруулан тайлагнасныг залруулав.

Аудитаар нийт 1.8 сая төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 1.7 сая төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

1.Сургуулийн захирал нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10/9 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт" -ийн дагуу эрхлэгчийн ур чадварыг үнэлж дүгнээгүй байхад Сумын Засаг даргын 2021 оны А/48 дугаар захирамжийг

Дэлүүн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үндэслэн 1,786.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл авсныг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

## 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

## 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн байх.	1	9.817.0			1	9.817.0	1	9.817.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>9.817.0</b>			<b>1</b>	<b>9.817.0</b>	<b>1</b>	<b>9.817.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/ Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шалгуур үзүүлэлт хангаагүй ур чадварын нэмэгдэл авсан	1	1,786.5	1	1,786.5								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,786.5</b>	<b>1</b>	<b>1,786.5</b>								

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

